



## ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

1402, Хөгжил хороолол, Жинст баг,  
Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82099  
Утас: 70-48-34-13. Факс: (976) 70-48-34-13,  
Цахим шуудан: govialtai@audit.gov.mn  
Цахим хаяг: www.audit.mn

2024.07.31 № 263

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд  
заасан шаардлагад нийцсэн талаарх  
дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5.4-т заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд 2024 оны Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох Говь-Алтай аймгийн Есөнбулаг сумын Монгол ардын намын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

### Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

2024 оны Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигч нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо, судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

### Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага нь 2024 оны Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817-1:2020 Төрийн аудит. Тулгуур зарчим, MNS6817-6:2020 Төрийн аудит. Нийцлийн аудитын зарчим, MNS6817-8:2020 Төрийн аудит. Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хууль, холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

0702 00865

## Дүгнэлт

Говь-Алтай аймгийн Есөнбулаг сумын Монгол ардын намын Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Говь-Алтай аймгийн Есөнбулаг сумын Монгол ардын намын мөрийн хөтөлбөр (...5... хуудас)-ийг хавсаргав.

Хувийг: Говь-Алтай аймгийн Есөнбулаг сумын Монгол ардын намд

Хувийг: Говь-Алтай аймгийн Есөнбулаг сумын Сонгуулийн хороонд

Хавсралт 5... хуудастай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР



Г.ГҮНЖИДМАА

ЕСӨНБУЛАГ СУМЫН  
МОНГОЛ АРДЫН НАМ

СУМЫН ИТХ-ЫН 2024 ОНЫ 9 ДЭХ УДААГИЙН  
ЭЭЛЖИТ СОНГУУЛЬД ДЭВШҮҮЛСЭН


**АЛТАЙН ШИНЭ СЭРГЭЛТ**

МӨРИЙН ХӨТӨЛБӨР  
(2024-2028)

2024 он

АГУУЛГА

НЭГ. ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО  
ХОЁР. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО  
ГУРАВ. ДЭД БҮТЦИЙН ХӨГЖИЛ  
ДӨРӨВ. БАЙГАЛЬ ОРЧИН АЯЛАЛ ЖУУЛЧИЛАЛ  
ТАВ. ЦАХИМ ХӨГЖИЛ ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ





## **НЭГ. ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО**

Хүний хөгжлийн үндсэн үзүүлэлтүүд болох эрүүл мэнд, боловсрол, нийгмийн бусад суурь үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлж, иргэн бүрт тэгш боломж бий болгож, хүний амьдрах таатай орчин нөхцлийг бүрдүүлэхэд онцгой анхаарч, өрх, иргэдээ тогтмол ажилтай, орлоготой байхад бүх талаар дэмжлэг үзүүлж, хүний амьдралын чанарыг сайжруулна.

### **1.1 ЭРҮҮЛ МЭНД**

1.1.1 Хүн амын дундаж наслалтыг нэмэгдүүлэх хүрээнд эрүүл мэндийн үзлэг, эрүүл мэндийг дэмжих төвийн үйл ажиллагааг эрчимжүүлж эрт илрүүлгийн хувийг жил бүр нэмэгдүүлэх

1.1.2 Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалтай уялдуулан АШУҮИС-ийн Говь-Алтай салбар сургуулийг түшиглэн “баруун бүсийн эрүүл мэндийн төв” сургуулийн түшиц эмнэлэг байгуулах

1.1.3 Явуулын эрүүл мэндийн тусламж үйлчилгээг баг бүрд тогтмол зохион байгуулж, цахим эрүүл мэндийн технологийг ашиглан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах үйл ажиллагааг өргөжүүлэх

1.1.4 “Жаргалан-Алтай ӨЭМТ-үүдийн байрыг шинээр барьж ашиглалтанд оруулах/ нэн шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах

1.1.5 Төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд аймагт “MRI, ангиографийн аппараттай болох” ингэснээр тусламж үйлчилгээний чанарт үсрэнгүй дэвшил гарна.

1.1.6 Анагаахын шинжлэх ухаан, технологийн дэвшил, инновацийг нэвтрүүлэх зорилгоор эрүүл мэндийн ажилтныг өндөр хөгжилтэй оронд бэлтгэх, дадлагажуулах

1.1.7 Хот, суурин, уул уурхайн бүс нутгийн агаар, ус, хөрсний бохирдолын шалтгаан, үр дагаврыг тандах, хүн амын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж байгаа хүчин зүйлийг бууруулах, арилгах цогц арга хэмжээг хэрэгжүүлэх

1.1.8 Хүн амын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх архи, тамхины хэрэглээг хязгаарлах, “Тамхигүй -Ирээдүй” хөтөлбөр боловсруулаж хэрэгжүүлэх

1.1.9 Эрүүл аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бий болгоход онцгой анхаарч суурин газруудын камержуулалтыг 80 хувиас дээш болгох

1.1.10 “Хүний хөгжлийн төв”-ийг бий болгож хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн суралцах, хөдөлмөрлөх нөхцөлийг бий болгох

### **1.2 БОЛОВСРОЛЫН САЛБАРТ**

1.2.1 Багш нарын мэргэжлийн тасралтгүй хөгжлийг дэмжих, мэргэжил дээшлүүлэх, гадаад дотоодын сургалт, үйл ажиллагаанд хамруулж “Алтайн-Чадварлаг багш” дэд хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

1.2.2 Орон нутаг, бүс, улс, олон улсын түвшинд зохион байгуулагдаж буй олимпиад, уралдаан тэмцээнд оролцож, амжилт үзүүлсэн суралцагч, багш нарыг дэмжиж, урамшуулах журам боловсруулж хэрэгжүүлнэ.

1.2.3 Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийг түшиглэн баруун бүсийн мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэх политехникийн сургууль болгон хөгжүүлнэ.

1.2.4 Ерөнхий боловсролын сургуулиудыг байгалийн ухааны лабортори, сургалтын хэрэглэгдэхүүн, тоног төхөөрөмжөөр хангах ажлыг үе шаттай хэрэгжүүлж боловсролын чанар, үр өгөөжид анхаарч ажиллана.

1.2.5 БАГШИЙН ХӨГЖЛИЙН ОРДОН-ыг ашиглалтанд оруулж орчин үеийн дэвшилтэт технологиор хангах ажлыг хэрэгжүүлнэ. Багш хөгжлийн төвийн үйл ажиллагааг тогтмолжуулж, орчин үеийн техник технологээр хангах ажлыг үе шаттайгаар зохион байгуулна.

1.2.6 Элсэлтийн ерөнхий шалгалт, хөндлөнгийн үнэлгээ, сургалтын чанараас хамаарч багш, сурагчдыг урамшуулах журмыг боловсруулж, багшийн үнэлэмжийг дээшлүүлэхэд анхаарч ажиллана.

1.2.7 Насан туршийн боловсрол хөтөлбөрийн хүрээнд орчин үеийн шинжлэх ухааны дэвшил болон амьдралын зохист хэвшлийн талаарх сурталчилгааг өргөжүүлнэ.

1.2.8 Сурагчдын гадаад хэлний мэдлэг, авьяас чадвар, бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх цогц арга хэмжээг авч аймгийн хэмжээнд хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлнэ. Хичээлээс гадуурх хүүхэд хөгжүүлэх сургалтын хөтөлбөр боловсруулж, сонирхол, авьяас чадварыг нээн хөгжүүлэх, сонгон, секц, дугуйлангийн үйл ажиллагааг өргөжүүлнэ.

1.2.9 Боловсролын салбар дахь бүтээн байгуулалтын ажлыг үргэлжлүүлнэ.

- АШУИС-ийн харьяа сургуулийн эмнэлгийн барилга,
- Есөнбулаг сумын 11-р цэцэрлэгийн спорт заалны барилгуудыг шинээр барих,
- Есөнбулаг сумын 2-р, 3-р цэцэрлэгийн барилгыг буулгаж шинээр барих, Есөнбулаг сумын 3-р сургууль,
- Алтай сумын сургуулийн барилга, Есөнбулаг сумын 3-р цэцэрлэгийн барилгад их засвар хийх ажлуудыг хийж гүйцэтгэнэ.

1.3 Хүүхдийн эрх, хөгжил, хамгаалалын тогтолцоог бэхжүүлж хүүхэд, гэр бүлд ээлтэй, тэгш боломж бүхий нийгмийн хамгаалалын дэд хөтөлбөр хэрэгжүүлнэ.

1.4 Хүүхэд залуучуудын хэрэгцээ шаардлагад суурилсан, сурч боловсрох, хөгжих, соёл хүмүүжил, хөдөлмөр эрхлэлтийг дэмжсэн “Алтайн баялаг–Залуус” хөтөлбөрийг үргэлжлүүлнэ.

1.5 Ахмад настны чөлөөт цагаа үр дүнтэй өнгөрөөх, мэдээлэл авах, хөгжих боломжийг бүрдүүлэх хөгжлийн төвийг байгуулна.

1.6 Спортын дасгалжуулагчдыг мэргэшүүлэх сургалтын тогтолцоог сайжруулж, биеийн тамир, спортын арга зүйчийн ажлын байрыг нэмэгдүүлж, шигшээ багийн спортын төрөл, бүрэлдэхүүний тамирчид амжилтаа ахиулан, улс, тив, дэлхийн түвшинд хүрэхэд дэмжлэг үзүүлнэ.

## **ХОЁР. ЭДИЙН ЗАСАГ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН БОДЛОГО**

2.1 Шинэ хоршоо-чинээлэг малчин хөдөлгөөнөөр дамжуулан, малын үүлдэр угсаа сайжруулах замаар таваарлаг мал бий болгож, ашиг шимийг сайжруулах ажлыг эрчимжүүлнэ.

2.2 Ноос, ноолуурын анхан шатны боловсруулалт хийх нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, үйлдвэр байгуулах хоршоодын санал санаачлагыг дэмжинэ.

2.3 Хүлэмж, агуулахын аж ахуйг хөгжүүлэх замаар хүнсний ногооны хэрэгцээг жилийн турш тогтвортой хангана.

2.4 Малын тэжээлийн үйлдвэрийг бүсчлэн байгуулах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, өвс тэжээлийн аюулгүй нөөцийг нэмэгдүүлнэ.



2.5 Орон нутгийн үйлдвэрлэл, үйлчилгээ, худалдаа, бирж, тээвэр логистикийн цогцолборыг кластераар хөгжүүлэх тохиромжтой байршлыг санал болгож, хүсэлт гаргасан хувийн хэвшил, хоршоодыг дэмжинэ.

2.6 Алтай нутгийн үйлдвэрлэл эрхлэгчдэд бизнесээ эрхлэх ур чадвар, санхүүгийн мэдлэг олгох сургалтуудыг зохион байгуулж зөвлөн туслах үйлчилгээ үзүүлж ажиллана.

2.7 Барилгын материал үйлдвэрлэлийн салбарыг бодлогоор дэмжиж барилга үйлдвэрлэлийн төрөлжсөн бригадуудыг бий болгож чадавхижуулах ажлыг МСҮТ, барилгын цэргийн анги болон аж ахуйн нэгжүүдтэй хамтран хэрэгжүүлж, Алтай хотыг орон сууцжуулах хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

## **ГУРАВ. ДЭД БҮТЦИЙН ХӨГЖИЛ**

3.1 Алтай хотод Автовокзалын барилгыг шинээр ашиглалтад оруулж тээврийн үйлчилгээг сайжруулна.

3.2 Алтай хотын төвийн цэвэр ус, ариутгах татуургын төв болон салбар шугамыг шинэчилж саарал усны технологийг нэвтрүүлнэ.

3.3 Алтай хотод олон төрлийн (орлогод нийцсэн, түрээсийн, ногоон) орон сууцны хангамжийг нэмэгдүүлж инженерийн хангамжтай орон сууцаар хангана. Үүнд:

А. Гэр хорооллын газрыг дахин зохион байгуулах төсөл-500 өрх

Б. Зөвшөөрөл олгогдсон барилгажилт төсөл-800 өрх

В. Шинэ суурьшлын бүс хөгжүүлэх төсөл-800 өрх

Г. Ашиглалтын шаардлага хангахгүй орон сууцыг дахин төлөвлөлтөд оруулах төсөл-100 өрх

3.4 Алтай хотын гэр хорооллыг цэвэр ус, бохирын системд холбосноор хашаандаа сайхан амьдрах боломж болоцоог бүрдүүлнэ.

3.5 Гэр хорооллын ЦДАШ-г шинэчилж, шинэ цахилгааны эх үүсвэрийг бий болгосноор, айл өрхүүдийг цахилгаан халаалтаар халаах бүрэн боломжтой болно.

3.6 Аймгийн төвийн хэрэглэгчдийн тоолууруудыг бүрэн ухаалаг тоолуураар сольж, сумдын төвийн хэрэглэгчдийн тоолууруудыг үе шаттайгаар шинэчлэнэ.

3.7 Агаарын тээврийн либералчлалыг хэрэгжүүлж, нислэгийн тоо, чиглэлийг нэмэгдүүлэн, өрсөлдөөнийг дэмжих замаар нислэгийн үнийг хямдруулна.

## **ДӨРӨВ. БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ**

4.1 “Ногоон–Алтай” хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлж Алтай хотын болон сумдын төвийн ногоон байгууламжийг үе шаттайгаар нэмэгдүүлнэ.

4.2 Бэлчээрийг хортон шавж, мэрэгчээс хамгаалах ажлыг үе шаттай зохион байгуулах

4.3 Хог хаягдлыг цэгийг байгальд ээлтэй аргаар нөхөн сэргээх, дахин боловсруулах

4.4 Хүүхэд залуучуудын чөлөөт цагаа өнгөрөөх, орчин үеийн тоглоом, тоног төхөөрөмж бүхий хүүхдийн паркийг ашиглалтанд оруулна.

## ТАВ. ЦАХИМ ХӨГЖИЛ, ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

5.1 Алслагдсан багийн төвд үүрэн операторийн сүлжээг оруулах ажлыг үе шаттай хэрэгжүүлэх

5.2 Төрөөс үзүүлэх үйлчилгээг дахин загварчилж орон нутгийн захиргааны байгууллагаас иргэн, ААНБ-ын цахимаар авах үйлчилгээний тоог нэмэгдүүлэх

5.3 Орон нутгийн мэдээлэл технологийн мэргэжилтэй албан хаагчдыг хөгжүүлэх, мэдлэг, ур чадварыг нэмэгдүүлэх

5.4 Төрийн албан хаагч улс төрөөс ангид дарамтгүй ажиллах боломжийг бүрдүүлж, албан хаагчдын хариуцлага, ёс зүйг дүгнэх иргэдийн үнэлгээний тогтолцоог хэрэгжүүлнэ.

5.5 Орон нутагт тогтвор суурьшилтай ажиллаж, 2 жил дараалан “маш сайн” үнэлэгдсэн албан хаагчийг гадаадад хэлний болон мэргэшүүлэх сургалтанд хамруулж, хүний нөөцийг бүрдүүлэх тэтгэлэгт хөтөлбөр хэрэгжүүлнэ.

5.6 Төрийн байгууллага, эдийн засаг, нийгэм соёлын хүрээнд жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, бүх түвшинд жендерийн мэдрэмжтэй бодлого хэрэгжүүлнэ.

ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ЕСӨНБУЛАГ СУМЫН  
МОНГОЛ АРДЫН НАМЫН ХОРОО

